

ТӨРИЙН УДИРДЛАГА, УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ-ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА

ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ ДЭХ ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГАА

*Б. Долгор
Доктор (Ph.D), профессор*

*Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
Шинжлэх ухаан, технологийн их сургууль*

dolgor@gmail.com

*Д. Ариунтогос
Багш, магистр*

*Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
Шинжлэх ухаан, технологийн их сургууль*

ariuntogsd@gmail.com

***Хураангуй:** Дэлхий нийтийн асуудал болсон цар тахлын нөхцөл байдал нь улс орон бүрийн амьдралын хэв маягт өөрчлөлт оруулж энэ нь цаашидаа тодорхой бус хугацаанд нийгмийн санаа бодолд хадгалагдсаар байх тийм цаг үед бид амьдарч байна. Энэ асуудлын хүрээнд олон нийтийн санаа бодлыг тодорхойлох онол, үзэл баримтлал, олон нийтийн санаа бодол, нийгмийн сүлжээний давуу бөгөөд сул талын талаар судалж цар тахал нь иргэд олон нийтийн тогтсон хандлагад хэрхэн нөлөөлж буйг судлах зорилго тавьсан болно. Тухайн нөхцөл байдалд социал мериа хэрхэн нөлөөлсөн зэргийг анкетийн аргаар судалж судалгааг өргөжүүлэх байдлаар бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын арга, баримт бичгийн шинжилгээний аргыг ашигласан.*

***Түлхүүр үгс:** Хол хорио, онцгой байдал, олон нийтийн сүлжээ, эвент*

УДИРТГАЛ

Дэлхий нийт цар тахлын нөхцөл байдлыг даван туулах шатандаа ороод байгаа ч түүнээс үүдэлтэй олон сөрөг үр дагаварууд гарсаар байна. Ийм цаг үед улс орон бүр өмнө ба дараах нөхцөл байдлыг судлах чиглэлээр олон судалгаа хийгдэж байна. Энэ нь нөхцөлт байдлаас богино хугацаанд хэрхэн гарах, олон нийтийн санаа бодлыг хэрхэн тогтоон барих асуудал эрдэмтэн

судлаачдын анхраалын төвд байсаар байгаа бөгөөд улс орон бүрийн бодлого боловсруулагчид шийдэлтэй арга хэмжээ авах үе шаттандаа явж байна хэмээн үзэж болно. Төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг бол онцгой нөхцөл байдалд оновчтой шийдвэр гаргах, иргэдэд бодит мэдээлэл өгөх, мэдээллийн эргэх холбоонд тулгуулан үе шаттай бодлого боловсруулах явдал билээ.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр)-ийн хүрээнд төрийн зүгээс иргэдэд хүрч буй мэдээлэл нь тогтмол байх, хүртээмжтэй байх, эргэх холбоотой байх, тэгш оролцоог хангах, хууль тогтоомжийн хүрээнд байх зарчимд тулгуурлан МҮОНРТ болон арилжааны сувгууд, орон нутгийн телевизийн сувгууд, FM радио, интернетийн сувгууд болон байгууллагын веб сайтууд, инстаграм, твиттер, фейсбүүк, баннер болон өдөр тутмын сонин, сэтгүүл, сурталчилгааны хэвлэмэл хуудсууд, зар сурталчилгааны самбарууд, тусгай дугаарын утас зэрэг нь иргэдэд мэдээллийг түгээх үүрэгтэй. Цар тахлын дараах нөхцөл байдал үүсээд байхад олон нийтийн санаа бодлыг судалсны үндсэн дээр төрөөс явуулж ирсэн хөнгөлөлт, тусламж, үйлчилгээг шат дараалалтай бууруулах замаар хорио цээрийг улаанаас, улбар шар, шар, ногоон бүсрүү шилжүүлэх үйл явц нийгмийн санаа бодолд төдийлөн нийцэхгүй өөрөөр хэлбэл шилжилтийн сэтгэл зүйд бэлтгэгдээгүйгээс иргэдийн амьжиргааны түвшин бодит байдлын хооронд гарч буй зөрүүтэй нөхцлөөс үүдэн хямралт нөхцөл байдал үргэлжилснээр байна.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

“Олон нийтийн санаа бодолд тодорхойлолт өгөхөөс түүний хэмжих нь амархан” гэж олон нийтийн харилцааг судлаачид үзсэн байдаг. XIX зууны сүүлчээр нийгмийн шинэчлэлийн явцад олон нийтийн талаар багц онолууд үүсэж түүний үндсэн дээр нийгмийн санаа бодлыг тандах, тодорхойлох оролдлогууд хийгдэж эхэлжээ. Хаадын угсааныхан, албан хаагчид, сэхээтнүүд, элит бүлгийнхэн, улс төрчид зэрэг дээд ангиллынхан нэр хүнд, эрх мэдлээ хадгалахын тулд олон түмний нэрийг барих үзэгдэл ихээхэн хөгжиж, өөр өөрийн арга барилаар олон нийтийг татах нь түгээмэл болжээ.

Энэ үеэс нийгэм судлаачид олон нийтийн санаа бодлыг тогтоон барих, хамгаалах, түүнд тулгуурлан үндэс угсаа, арьс өнгө, улс төр, бизнес, урлаг соёлын эвэнт зохион байгуулах болсноор олон нийтийн санаа бодлын судалгаа шинэ үе шатанд орсон байна. Боловсрол, шинжлэх ухаан, шашны тэргүүлэх үзэлтнүүд олон нийтийн санаа бодолд нөлөөлөхдөө мэдээллийн хэрэгсэл, уран илтгэгчдийг ашиглан мэдлэг түгээх, өөрийгөө таниулах, онол үзэл баримтлалаа хамгаалах зэргээр олон нийттэй харилцах (PR-ийн) арга

технологийг ашиглах болсноор зарим нэгний олон нийтийг төөрөгдүүлж ирсэн зохимжгүй байдлыг халах, үнэн бодит мэдээлэл өгөхөд туслах болсон байна. Олон нийтийн санаа бодол төлөвшин бүрэлдэхэд дараах нөхцөл байдал нөлөөлдөг. Үүнд:

1. Газар зүйн хувиарлалт (тив, бүс нутаг, улс, муж, хот, тосгон гэх мэт)
2. Хүн ам зүйн хүчин зүйл (нас хүйс, арьс өнгө, үндэс угсаа, гэр бүлийн байдал, орлогын хэмжээ, ажил төрлийн байдал, боловсрол, шашин шүтлэг, итгэл үнэмшил гэх мэт)
3. Сэтгэлзүйн байдал (анги, давхарга, амьдралын түүх, дүр төрх бие хүний байдал, темперамент гэх мэт)

Нийгмийн онолчид ба хэвлэл мэдээллийнхэн ХХ зууны турш олон нийтийн асуудлаар маргаж байгаа бөгөөд 1961 онд Америкийн эрдэмтэн Бернард Берелсон “Соёлын ардчиллын талаарх аугаа маргаан” хэмээн бүтээлдээ олон нийтийн судлаачдыг дараах гурван бүлэгт хуваан үзсэн байна.

I. Practicus буюу хэвлэл, мэдээллийн салбарт ажиллагсад

II. Academicus буюу олон түмний нийгмийн онолчид

III. Empiricus буюу олон түмний харилцааг туршилт ба ажиглалтын аргаар судалдаг хүмүүс юм.

Олон нийтийн нийгмийн онол сул болон давуу талтай учир нь олон нийтийн санаа бодолд тодорхойлолт нь ихээхэн төвөгтэй байдагтай холбоотой.

Олон нийтийн нийгмийн онолын сул тал:

- Хэвлэл мэдээллийн шууд тусгалын нөлөөллөөр санаа болол нь бүрэлддэг тул өөрсдийгөө сул гэдгээ мэдэрч буй олон нийт бөгөөд тэднийг “дундаж хүмүүс” хэмээн үзэх хандлага байсаар байна. Өөрөөр хэлбэл шинжлэх ухаанч биш байдлаар нэгддэг.
- Олон нийтийн онол тогтсон системгүй, динамак шинжтэй буюу зүй зүй тогтолгүй байдаг
- Олон нийтэд хүргэх мэдээлэл, эргэх холбоо нь эрх мэдлээ хадгалж үлдэх эрмэлзлэлтэй элитүүдээр дамжин түгээгддэгтай холбоотой.

Харин олон нийтийн нийгмийн онолын давуу тал:

- Олон нийт чухал гэсэн нийгмийн сэтгэлгээг төлөвших
- Олон соёлын маргаантай нөхцөлд олон нийтийн бүтэц, өөрчлөлтийг тооцсон байдаг
- Хэвлэл мэдээллийн байгууллага, судалгааны ажилтны ёс зүй, хариуцлагын асуудлыг олон талаас авч үздэг.

Г.Гегель “Олон нийтийн санаа бодолд ардын мэргэн санаа агуулагдаж байдаг хэдий ч үүнийг дээд үнэн хэмээн үзэх нь учир дутагдалтай” гэжээ. Олон нийт санаа бодлыг тодорхойлохдоо нийгмийн их ба бага бүлгүүдийг судлах шаардлагатай. Их бүлэг бол улс, олон нийтийн цар хүрээнд орших хүмүүсийн

хамтлаг бөгөөд хувийн болон нийгмийн янз бүрийн хэв шинжийн холбоонд тулгуурладаг. Их бүлгийг угсаатан зүй болон хэлний шинжлэлийн аргуудаар судалж санаа бодлыг тодорхойлох нь түгээмэл байдаг. Францын эрдэмтэн С.Московийн “нийгмийн төсөөлөл” гэсэн концепцид бүлэг бүр өөрийн дүр төрхөө тодорхойлдог бөгөөд энэ нь бүлгийн туршлага, үйл ажиллагаанаас хамаардаг гэж үзсэн. Их бүлгийн санаа бодол тогтвортой байх нь бусад бүлгийн гишүүдийг нэгтэх нөхцөл болдог гэжээ.

Г.Г. Дилигенский их бүлгийг үүсэх хугацаагаар нь:


- Санамсаргүй байдлаар үүссэн, богино хугацаанд оршин тогтнодог (үзэгчид, сонсогчид)
- Нийгмийн хөгжлийн түүхийн явцад үүсэн бий болсон, удаан хугацаанд оршин тогтнох чадвартай (үндэстэн, ажил мэргэжлийн бүлгүүд)

Их бүлгийг тусгай зохицуулагч хэрэгсэл буюу уламжлал, ёс заншил, хүсэл сонирхол, ижил хэлээр ярих байдал зэрэг нийтлэг шинжүүдээр хэмжиж болно.

Г.Г.Дилигенский, А.И. Горячева, Ю.В. Бромлей нарын үзэл санаанд тулгуурласан

Их бүлэг нь:

- Тогтмол шинжтэй сэтгэлзүйн бүрдэл болсон хэсэг буюу угсаатан, нэг хэлний бүлгийнхэн, үе залгамжилсан элит хэсэг
- Хөдөлгөөнт шинжтэй сэтгэл зүйн харилцаанд тулгуурласан бүрдэл болох тодорхой эрх ашгийн төлөө жагсагчид, бөөгнөрсөн олон нийт хэмээн ангилж болно.



Бага бүлэг нь хэмжээгээрээ цөөн, дотно, харилцаатай, тогтмол оршиж байдаг, бие биенээ хүлээн зөвшөөрсөн хүмүүс буюу ажлын хамт олон, гэр бүл, ангийнхан, нэг сүмд цугларагсад, улс төрийн намынхан багтах хэдий ч зарим нь нь бүрэн хэлбэржээгүй байх онцлогтой.

Цар тахлын эхний нөхцөлд их бүлгийн санаа бодол давамгайлж байсан бол цар тахал бүх тив, бүс нутаг, улс орныг хамарсны дараа бага бүлгийн санаа бодолд тулгуурлан асуудлаа тодорхойлох, шийдвэрээ гаргах байдал түгээмэл ажиглагдаж байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгааны зорилго нь: Дээрх судалгаа нь цар тахлын үед олон нийтийн санаа бодолд нөлөөлж байсан асуудлуудыг 15 асуулга бүхий судалгаагаар авч иргэд хэрхэн зохицон амьдарч ирсэн нөхцөл байдлыг тодорхойлон энгийн нөхцөл байдалд шилжихэд тэдэнд тулгарч болох асуудлыг тодорхойлоход чиглэгдсэн болно.

Судалгаанд 118 хүн оролцсноос хүйсийн байдал 74/26 харьцаа байгаа нь эрчүүдийн асуудалд анхаарал сул хандуулж буй байдлын нэг тал гэж үзэж байна. /судалгааг хүйсийн хувьд адил хүмүүст хүргэсэн болно/. Насны хувьд 41-59 хүмүүс 49% эзэлж, 21-41 насны хүмүүс 45% орчим байгаа нь тухайн асуудал олон нийтийн цар хүрээг хамарсан байдал болохыг илэрхийлж байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд төрийн байгууллагын ажиллагсад олонхи байсан нь цар тахал төрийн ажил албаны үйл явцад илүү нөлөөлж байсан гэж үзэж байна.




Зураг. Ажил, хөдөлмөр эрхлэлтийн байдал

Судалгаанд оролцогчдын 47.1% нь төрийн байгууллагад, 23.5% нь оюутан, 14.3% нь бизнесийн байгууллагад, 8.4% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 4.2% нь тэтгэвэрийн хүмүүс байгаа бол, 2.5% нь одоогоор ажил эрхлээгүй иргэд оролцсон байна.


2. Цар тахал гарцаагүй дэлхий нийтийг хамрах байсанд олон нийт сэтгэл зүйн хувьд бэлтгэлтэй байсныг тодорхойлж байна.
3. Цар тахлын нөхцөлд гэрээсээ гарахгүй байх хариултыг 68.9% нь сонгосноос үзэхэд хамгаалах үндсэн операци болж байсан. Тиймээс энэ цар тахлын үед гэр бүл, үр хүүхэддээ анхаарал хандуулах явдал, олон өдөр, цагийг хамтдаа өнгөрүүлж байсан нь тухайн үеийн нөхцөл байдлын бас нэг эерэг таатай зүйл болсон нь харагдаж байна. Харин тухайн нөхцөл байдлын үед төр засгаас гаргасан шийдвэрт бага үнэлгээг өгчээ.
4. Хамгийн чухал гэсэн хариултад сонгох 8 хувилбараас гэрээсээ гарахгүй байх 65.3%, зочин урихгүй байх 33.1%, нийтийн тээврээр зорчихгүй байх 31.4%, үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй байх

25.4% зэрэг сонголтыг хийсэн нь тухайн үед засгийн газраас явуулсан шийдвэртэй санал нийлж байсныг харуулж байна.




Зураг. Цар тахлын үеийн нөхцөл байдал

5. Мэдээллийн эх сурвалжуудын алинд нь илүү ач холбогдол өгч байсан талаарх асуулганд МҮОНРТ-д 52.1% гэж хариулсан байгаа ч нийгмийн сүлжээнээс мэдээлэл авах нь илүү байна. Цар тахлын үед мэдээлэл хэрхэн авч байсан, мэдээллийн ямар сувгийг ашиглаж байсан байдлыг гурван багц асуулгын талаар судалж үзвэл өдөр бүрийн 11 цагийн мэдээг хамгийн бодит гэж үзэн ач холбогдол өгсөн, мөн цар тахлын өмнөх үеэс интернет өргөнөөр ашигладаг байсан ч фейсбүүк /Facebook/-т хандагчид огцом өсөж 86.6% болж эрс нэмэгджээ.



Зураг. Олон нийтийн сүлжээний хандалт


Судалгаанд оролцогчдоос цар тахлын өмнө интернет (олон нийтийн сүлжээ) хэр ашигладаг талаарх асуулгад байнга ашигладаг 67.2%, хааяа ашигладаг 21%, ажлын шаардлагаар ашигладаг 11.8% гэж хариулсан бол огт ашигладаггүй гэж хариулсан хүн нэг ч байхгүй байгаа нь олон нийтийн сүлжээг хэр өргөн ашигладаг болохыг харуулж байна.



Зураг. Цар тахлаас өмнөх олон нийтийн сүлжээг ашигладаг байсан байдал

- Цар тахлын нөхцөлд төрөөс авч хэрэгжүүлсэн бодлогын хамгийн оновчтой нь цахилгаан дулаан, түлшний хөнгөлөлт, гэрээс ажиллах нь олон нийтийн санаа бодолд илүү нийцсэн байна. Энэ нь төрийн бодлыг оновчтой шийдвэрийн нэг хэсэг болжээ.

Харин эсрэгээрээ тухайн үед иргэдийн бухимдлыг ихээр төрүүлж байсан шийдвэр юу байсан талаарх асуултанд цагдаа болон онцгой байдлын газраас авч байгаа арга хэмжээг хоорондоо уялдаа холбоо, авцалдаагүй гэж 43.7%, засгийн газрын ажиллаж байгаа байдал гэж 42.0% нь, мэдээллийн зөрүүтэй байдал гэж 22.7%, эмнэлгийн үйлчилгээ гэж 21% нь хариулжээ.



Зураг. Цар тахлын үед авч байсан арга хэмжээ тухай

- Цар тахлын нөхцөл хамгийн хэрэгцээтэй чадвар буюу өөрийгөө хөгжүүлэх нь мөнгө санхүүгээ зохицуулах, интернетийн оршин ажиллах чадваа нэмэгдүүлэх, гэр бүл хүүдэтэй дээ тавих анхаарал халамждаа анхаарах шаардлага нэмэгдсэн бол хамгийн төвөгтэй байдал бол чөлөөтэй гарч орох байдал хязгаарлагдснаар бүх нийтээрээ стресстэхэд нөлөөлсөн байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Цар тахлын нөхцөл байдалд нийгмийн санаа бодлыг тогтвортой барих, иргэдийн үндсэн эрх ашгийг хамгаалах, төрийн үйл ажиллагааны үндсэн

зарчмыг баримтлах, шинжлэх ухааны ололтыг амдралд хэрэгжүүлэх, иргэдтйн амьжиргааг дэмжих хүрээнд олон нийт рүү чиглэсэн олон сургалт, судалгаа, эвент, мэдээлэл сурталчилгаа хийгдэж онлайн орон зайд бүх нийтээрээ амжилттай ажиллаж ирсэн гэж үзэхээр байна. Тухайлбал,

- “Ковид-19” халдварт цар тахалтай холбогдуулан “Цар тахлыг хохирол багатай даван туулах арга зүй” сэдэвт онол практикийн бага хурал-2021.
- “КОВИД-19 цар тахлын үеийн сэтгэцийн эрүүл мэнд ба тархи судлал”-ОУ-ын цахим хурал 2021
- ОУХА-ийн 20 сая ам.долларын дэмжлэгтэй Монгол улсад хэрэгжүүлэх “Онцгой байдлын үеийн дэмжлэг ба хөдөлмөр эрхлэлтийн төсөл” нь КОВИД-19 цар тахлын хямралын үед зохих шалгуурыг хангасан ажилчид, ажил олгогчдод түр хугацааны дэмжлэг үзүүлж, бичил бизнес эрхлэгчдэд тусласан юм.
- Хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй дам нөлөөг бууруулахын тулд Боловсролын Чанарын Шинэчлэл төслийн хүрээнд 5 сая ам.долларыг Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн санхүүжилтийг нөхөхөд зориулахаар болов.
- Цар тахлын үеийн гэрээ эрх зүйн зарим асуудлууд /подкаст цуврал/ - 2021 оноос
- КОВИД-19 цар тахлын улмаас анх удаа цахимаар зохион байгуулагдаж буй Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурлын 109 дүгээр чуулган Швейцарын Женев хотод болж 176 улсын Засгийн газар, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын 3900 орчим төлөөлөгч оролцож “Ур чадвар ба насан туршийн суралцах үйл ажиллагаа”, “Тэгш бус байдал ба хөдөлмөрийн ертөнц” гэсэн хоёр үндсэн сэдвээр хөндөн ярилцав.
- “Ковид-19 цар тахлын үед INSPIRE стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлж, Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох нь” Ази Номхон далайн бүсийн цахим хурал-2022.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас COVID-19 нь пандеми буюу цар тахал хэмээн зарласан 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс 7 тэрбум гаруй хүмүүс, 200 гаруй улс орон болзошгүй эрсдлээс өөрийгөө болон улс орноо хамгаалах нэгдмэл ажиллагаанд шилжиж улс орон бүр төрийн бодлогын хүрээнд иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлж байна. “COVID-19” нь өмнөх үеэс илүү өргөн хүрээг хамарсан нөхцөл байдал нь үүсгээд байна.

- Тахлын эх үүсгэвэр тодорхойгүй байгаа түүнтэй хийх “тэмцэл”-д удаашрал үүсгэсэн

- Мэдээллийн зөрүүтэй байдал нь мэдээлэл технологийн давуу тал гэхээс илүү сул тал болох нь ажиглагдаж байна.
- Мэдээллийг үндсэн эх сурвалжаас салгаж улс төр, эдийн засаг, соёлын ялгаатай байдалд тулгуурлах болсноор олон нийтийн дунд төөрөгдөл, тодорхойгүй байдал, үл итгэлцлэлд хүрч байна.

Олон нийтийн санаа бодолд мэдээлэл харилцааны технологийн хурдацтай хөгжил нь нийтийг хамарсан аливаа хямрал нөхцөлд мэдээллийг түргэн шуурхай хүргэхэд өндөр ач холбогдолтой боловч олон нийтийн санаа бодлыг тогтоон барих, хадгалахад, төлөвшүүлэхэд төвөгтэй байдал үүсгэдэг.

ДҮГНЭЛТ

Монгол улсад зөөврөгдсөн халдварын тохиолдол 2020 оны 3-р сарын 10-нд бүртгэгдэж, 2020 оны 11-р сарын 11-ээс цар тахлын нөхцөл бий болсноос хойш хоёр жил орчим хугацаанд олон нийтийн санаа бодол, амьдралын хэв маягт өвөрмөц байдал үүссэн нөхцөл байдал өнөөдөр ч бүрэн арилгаагүй өдөр бүр цар тахлын тохилдол бүртгэгдсэн хэвээр. Дэлхий нийтэд цар тахлын дэгдэлтийн бууралтын үе эхэлж, энэ бүх цаг үеийн туршид төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөлөл нь олон нийтийн санаа бодолд туссанаар таатай байдалд шилжиж эхэлж байна. Үүнд:

1. Цар тахлын үед 70 гаруй хууль эрх зүйн баримт бичиг батлагдаж, шинэчлэгдснээр эрх зүйн шинэ орчинд олон нийт зохицон ажиллах чадвар сайжирчээ.
2. Улбар шар, шар бүсийн байдалд орсноор бүх нийтийн мэдээллийн хэрэгсэлээр явагддаг “цар тахлын мэдээллийн тархи угаалт” багассанаар иргэдийн сэтгэлгээ чөлөөлөгдөж цар тахлын өмнөх цаг үедээ алхам алхамаар шилжиж байна
3. Олон нийт, иргэд хязгаарлагдмал орон зайд амьдрах хорио цуцлагдснаар нийгэмшилтийн процесс сэргэж “амьд харилцаа”-ны утга учир илүү үнэ цэнэтэй болсоор байна.
4. Онлайн орон зайд ажиллах нь зарим талаар ач холбогдолтой байсан хэдий ч төр бизнесийн бүх салбарт ажлын чанар, үр ашиг дээшилж эхэллээ.
5. Цар тахлын үеийн хөл хорионы нөхцөл байдал нь хүмүүст интернет орчинд ажиллах, түүнээс олон зүйлийг сурч мэдэж авч байгаа сайн талтай ч хил хязгааргүй олон цагийг сошиал орчин өнгөрөөж байсан нь хүмүүсийн өдөр тутмын амьдралын хэв маягт багагүй өөрчлөлтийг оруулж байсан.

НОМ ЗҮЙ

[1] Б. Долгор “Олон нийттэй харилцах ажил” УБ., 2009.

[2] Ф.И.Шарков Н.Болдбаатар “PR гарын авлага” УБ., 2006

- [3] Б.Энхболд “Олон нийттэй харилцах урлаг” УБ., 2007
[4] Б.Болд-Эрдэнэ. “Олон нийтийн харилцаа” УБ., 2010
[5] А.Оюунгэрэл “Олон түмний харилцааны онол УБ., 2009.
[6] Лахани Д, “Тархи угаах урлаг буюу хүссэнээ хүртэх жор”. УБ., 2009
[7] “Олон нийттэй харилцах ажил” ШУТИС. УБ., 2013
[8] А.Б.Зверинцев “Мэдээлэл харилцааны менежмент, PR” УБ., 2003